



**ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2026 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 01

Өмнөдэлгэр сум

Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
2026-2028 онд хэрэгжүүлэх Үндсэн чиглэл
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Есдүгээр хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2026-2028 онд баримтлах бодлого чиглэлийг хавсралтаар баталсугай.
2. Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2026-2028 онд баримтлах бодлого чиглэлийг ажлын төлөвлөгөөнд тусган жилийн эцэст иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнаж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, Хороодод даалгасугай.

ДАРГА 28.01 Ц.ПҮРЭВДОРЖ



D.disc /alban bichig/ ITH togtool

2326001 1

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны
03 дугаар сарын 30 -ны өдрийн Есдүгээр
хуралдааны 01 дугаар тогтоолын
1 дүгээр хавсралт

ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2026-2028 ОНД БАРИМТЛАХ БОДЛОГО, ЧИГЛЭЛ

1.1. Энэхүү үйл ажиллагааны баримтлах бодлого, чиглэл нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын алсын хараа, зорилго, зорилт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний суурь баримт бичиг бөгөөд сонгуулийн хөтөлбөр, аймгийн Хурлын үндсэн чиглэл, өөрийн шийдвэрээр томилогдсон сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, хөгжлийн бодлогын бусад баримт бичигтэй агуулга, ач холбогдлын хувьд адил болно.

1.2. Энэхүү үйл ажиллагааны баримтлах бодлого, чиглэлийг 2026-2028 онд хэрэгжүүлэх бөгөөд тайланг жил бүр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдаанд танилцуулна.

1.3. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бодлого, үйл ажиллагааг эрэлттэй, нээлттэй байх, Төлөөлөгч бүрэн эрхээ хуулийн хүрээнд тасралтгүй хэрэгжүүлэх, иргэд сонгогчдынхоо санаачлага, ажлыг дэмжих боломжийг хангасан, эргэх холбоотой байхаар төлөвлөж байна.

НЭГ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ, НУТГИЙН УДИРДЛАГА

1.1. Иргэдийн хууль, эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэх, нутгийн өөрөө удирдах ёс, төлөөллийн ардчиллыг сурталчилж, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр зорилтот ажлыг зохион байгуулна.

Төлөөлөгчдийг чадавхжуулах, сум, дүүргийн нутгийн өөрөө удирдах байгууллага болон гадаад улс орны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй танилцуулах, туршлага судлуулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх ажлыг зохион байгуулна.

1.2 Хурлын зөвлөл, Хороо, түр хороо, Хурлын дэргэдэх салбар зөвлөл, Хурлаас байгуулагдсан ажлын хэсгийн ажиллах нөхцөлийг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

1.3 Сумын Засаг даргын 2026-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, зохих хөтөлбөр, төлөвлөгөө, чиглэл эрх зүйн зохицуулалт зэргийг хэлэлцэж шийдвэрлэнэ.

1.4 Хууль тогтоомж, Улсын Их Хурал, Засгийн газар, бүх шатны Хурлын байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэр, нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актыг сурталчлах, хэрэгжилтийг тооцох, хяналт тавих ажлыг хэрэгжүүлнэ.

1.5 Хурлын шийдвэр, үйл ажиллагаанд иргэд олон нийт, иргэний нийгмийн байгууллагын оролцоог ханган хэвшүүлж, хурлын үйл ажиллагааг нээлттэй ил тод явуулж олон нийтийн хяналтыг бий болгоно.

1.6 Төлөөлөгч иргэд сонгогчидтойгоо эргэх холбоо тогтоох үйл ажиллагааны зардлыг шийдвэрлэж “Төлөөлөгчийн өдөр”-ийг жил бүр зохион байгуулах

1.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй, оновчтой зохион байгуулж, гэмт хэрэг зөрчлийг бууруулах түүний шалтгаан нөхцөлийг арилгах ажлыг эрчимжүүлнэ.

1.7 Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, цахим ур чадварыг дээшлүүлэх, сургах, туршлага судлуулах, сурч хөгжих таатай орчин бүрдүүлж нийгмийн баталгааг хангах хөтөлбөр төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулна.

ХОЁР: НИЙГЭМ, ХҮНИЙ ХӨГЖИЛ

2.1 Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч ажиллана.

2.2 Хүн бүрд тэгш хүртээмжтэй чанартай боловсрол эзэмшүүлэх, чадварлаг багш нараар хүний нөөцийг бүрдүүлэхийг бодлогоор дэмжинэ.

2.3 Бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, хөдөлмөр эрхлэлт, жижиг, дунд бизнес эрхлэлтийг бодлогоор дэмжиж, иргэдийн амьдралын чанарыг нэмэгдүүлнэ.

2.4 Түүх, үндэсний өв соёл, ёс заншил, соёл, урлаг, утга зохиолыг нийтэд сурталчлах түгээн дэлгэрүүлэх замаар үндэсний бахархал, нийгмийг соён гэгээрлийг төлөвшүүлэх ажлыг дэмжинэ.

2.5 Бүх нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, шилдэг тамирчдыг бэлтгэх, хөгжүүлэх, спортын ээлтэй орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.

2.6 Иргэд нийгмийн идэвхтэй бүлэг, төрийн бус байгууллага, хүүхдийн оролцооны байгууллага, сайн дурын хөдөлгөөн болон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллана.

2.7 Иргэд олон нийтийг соён гэгээрүүлэх лекц, сургалт, сайн үйлсийн аян, иргэдийг алдаршуулах, урамшуулах ажлыг олон нийтийн байгууллагуудтай хамтарч зохион байгуулж ажиллана.

ГУРАВ: ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ

3.1 Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлж, хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийг тогтвортой байлгахыг чухалчилж ажиллана.

3.2 Орон нутгийн онцлогт тохирсон шинэ санаа, оюуны бүтээл, брэндэд тулгуурласан үйлдвэрлэл өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн тоог нэмэгдүүлэх, сурталчлах, олон нийтэд таниулах, зах зээлийн хүрээг тэлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.3 Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийг үр ашигтай, хариуцлагатай зарцуулахад хяналт тавьж, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж ил тод байдлыг бий болгоход анхаарч ажиллана.

3.4 Гадаадын хөрөнгө оруулагчид олон улсын төсөл хөтөлбөр болон сайн хөршийн харилцаатай орнуудтай эдийн засаг, нийгэм, соёлын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

3.6 Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлнэ.

3.7 Дэд бүтцэд суурилсан, иргэнд ээлтэй ногоон хөгжлийг дэмжигч сум байж иргэдийг эрчим хүчний хэмнэлттэй тохилог амины орон сууцжуулах, амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх ажлыг дэмжинэ.

3.8 Орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, үр өгөөжийг нэмэгдүүлж, хяналтыг сайжруулах орон нутгийн өмч, хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, бүртгэл хяналт зарцуулалтыг сайжруулна.

ДӨРӨВ: БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ

4.1 Хэнтий аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх -2030” бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг сум орон нутагт уялдуулж ажиллана.

4.2 Байгаль орчин, ан агнуур, хөрсний бохирдол, ус, ой модны ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж, хариуцлагатай уул уурхайг бий болгоход чухалчилж ажиллана.

4.3 Эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулж, малыг эрүүлжүүлэх тоог чанарт шилжүүлж бэлчээр ашиглалтыг сайжруулахыг бодлогоор дэмжинэ.